

“Эмнэлгийн техник” ХК-ийн  
хувьцааг бүртгэлээс хасах тухай

“Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 6.2.2, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 34.1.7, “Компанийн тухай” хуулийн 23 дугаар зүйл болон “Эмнэлгийн техник” ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын 2007 оны 1 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Эмнэлгийн техник” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 179847 ширхэг хувьцааг нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны бүртгэл, Хөрөнгийн биржийн жагсаалт, Үнэт цаасны төлбөр тооцооны төвийн бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газрын дарга /Э.Ганбат/, “Хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “ҮЦТТГХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Компанийн зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж байгаатай холбогдуулан хуулиар хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Эмнэлгийн техник” ХК /Н.Баттогтох/-д үүрэг болгосугай.

3. Улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэж тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-г даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ